[https://m.facebook.com/story.php?story\\_fbid=pfbid0tiXUCo5HXZ7pjm1xnuWYWcxgmjs6bTbu2oM9Z6jQmRbveVSFACbUKuWLzsddbUNI&id=100009885192437&mibextid=NnVzG8](https://m.facebook.com/story.php?story_fbid=pfbid0tiXUCo5HXZ7pjm1xnuWYWcxgmjs6bTbu2oM9Z6jQmRbveVSFACbUKuWLzsddbUNI&id=100009885192437&mibextid=NnVzG8)
  
- 4) Цахилгаан хэмжүүр  
[https://m.facebook.com/story.php?story\\_fbid=pfbid02jkU1pU8MCf7tct2u7XNz2G8Puc8oU8VTrd7xaP8s8cvHuiXibtDCaGBnEZQhJhUxl&id=100009885192437&mibextid=NnVzG8](https://m.facebook.com/story.php?story_fbid=pfbid02jkU1pU8MCf7tct2u7XNz2G8Puc8oU8VTrd7xaP8s8cvHuiXibtDCaGBnEZQhJhUxl&id=100009885192437&mibextid=NnVzG8)
  
- 5) Автомат удирдлагын системийн тохируулга, туршилт  
[https://m.facebook.com/story.php?story\\_fbid=pfbid02XNdPD6cdBkj7TjuQj4tiAtFHbM6C2gKu9xMZK3zZmtHtizYrxHRN4zNbh8dLNKxl&id=100009885192437&mibextid=NnVzG8](https://m.facebook.com/story.php?story_fbid=pfbid02XNdPD6cdBkj7TjuQj4tiAtFHbM6C2gKu9xMZK3zZmtHtizYrxHRN4zNbh8dLNKxl&id=100009885192437&mibextid=NnVzG8)

Лабораторид хичээллэсэн байдал оюутан, сурагчид



THE ENGLISH SCHOOL OF MONGOLIA  
INTERNATIONAL SCHOOL LLC

Ulaanbaatar- 49, P.Box-654  
Tokyo Street-89, 1<sup>st</sup> Khoroo, Bayanzurkh District  
Phone: 451265, Fax: 976-11-451230  
E-mail: [info@esm.edu.mn](mailto:info@esm.edu.mn)

134 № 2023. 03.27  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**To Whom It May Concern**

This letter is to certify that Natsagnyam NAMKHAI, has been conducting a volunteering onsite laboratory tutorial for students at The English School of Mongolia in his laboratory room, 507 Main Library, ShUTIS, from 2015 to 2017.

Natsagnyam NAMKHAI has demonstrated exceptional expertise in his field, and his laboratory tutorial has been well received by students and faculty alike. Natsagnyam has shown a commitment to providing a hands-on learning experience to students, and has consistently gone above and beyond in ensuring that all participants receive a high-quality education.

We fully endorse his laboratory facilities at the ShUTIS, and highly recommend his tutorial to the Ministry of Education through ShUTSAN. We are confident that Natsagnyam and his laboratory will continue to provide an outstanding educational experience to students.

GRAHAM HILL



DIRECTOR



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ  
ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛЬ

Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191  
Утас/Факс: (976-11) 32 35 79,  
Цахим шуудан: pes@must.edu.mn,  
Цахим хуудас: www.must.edu.mn

2023.03.28 № 02/90

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН  
САНД

ШУТИС-ийн Төв номын сангийн 5-р давхарын 516 тоот өрөөнд байрлах “НаНям” лабораторит манай сургуулийн цахилгаан системийн автоматик болон цахилгааны инженерийн салбарын 8-12 оюутан 2020-2021 оны хичээлийн жилд хуваарьтай хичээлээс гадуур, сонгон суралцах зарчмаар тус лабораторид хичээллэн инженер Нацагнямын заасан лаборатори, практикийн хичээлд оролцож байсан болохыг тодорхойлов.

С.ЧА-НЫ ДАРГА




Ч. УЛАМ-ОРГИЛ

367770138





## Ажлын аргачлал, үр дүнг хэлэлцүүлсэн байдал



"НАМХАЙНАЦАГ НЯМ" ХХК

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ  
ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛ

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг  
Чингисийн өргөн чөлөө,  
Утас: 976-70043316, Факс: (+976-11) 70041274  
Цахим шуудан: info@edc.energy.mn

2013.11.01 № 12

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Тодорхойлолт

Эрчим хүчний хөгжлийн төвийн дэргэдэх Техникийн зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 05 дугаар хурлаар танай компаний шинээр санаачлан зохион бүтээсэн "Турбин генераторын өдөөлтийн автоматик, АРН/АРВ"-цахим төхөөрөмжийг авч хэлэлцэхдээ урилгаар ДЦС-2 ТӨХК-ний инженер Батсайхан, Батбаяр, ДЦС-4 ТӨХК-ний инженер Батзориг, Мөнхтөр, ЭХИС-ийн багш Ч.Нацагдорж, ЭДЦС ТӨХК-ний инженер Цогт-Эрдэнэ, СҮЦ-ийн багш Амгалантуяа, Баатар, Хишигдэмбэрэл, Цоодол, ЭХХТ-ийн инженер Базаррагчаа нарыг оролцуулан харилцан хэлэлцүүлэг өрнүүлсэн. Хурлаар "Намхайннацаг ням" ХХК-ны зохион бүтээсэн синхрон генераторын удирдлага болох "NaNyam-AX12" типийн өдөөлтийн цахим электрон автомат систем нь барууны технологийг Монголын техникийн нөхцөлд нийцүүлэн сайжруулсан анхны үндэсний бүтээл болжээ.

Барууны cosφ баригч автомат нь манай сойзтой өдөөлтийн машинтай системд сойз хэт халааж шатаах аюултай. Иймд "NaNyam-AX12" дахь cosφ баригч автомат нь реактив чадлын ихсэлтийг тодорхой утгаас эхлэн хязгаарлаж өгсөнөөр сойз хэт халж шатах аюулаас хамгаалдаг. Энэ давуу талаараа ДЦС-2-ын 1-р турбин генераторыг хагас жил тасралтгүй амжилтай удирдаж байна.


Дотооддоо өөрсдийн оюун ухаанаараа програм болон техник хангамжийг зохион бүтээснээрээ гадны импортын эсрэг өрсөлдөх чадвартай.

"NaNyam-AX12" доторхи тристорын удирдлага, стабилизатор, актив-реактив чадлын датчик, телемеханик, хүнд нөхцлийн тэжээлийн блок зэрэг электрон хавтангуудыг тус тусад нь инженерийн бүх салбарт өргөнөөр нэвтрүүлж импортыг бүрэн хаах боломжтой.

Мөн энэ бүтээлтэй уялдуулан виртуаль лаборатор буюу симулятор болон animation зохион бүтээсэн байна. Үүнд:

Автомат тохируулгын онолд ашигладаг өндөр нам давтамжийн филтерүүд, интеграль болон дифференциаль функцүүдийн симулятор болон animation, актив реактив чадлын эгшин зуурын утгууд фазын зөрүүнээс хэрхэн хамаарахыг animation-аар үзүүлдэг виртуаль генератор. Эдгээр нь сургалтын асар их ач холбогдолтой ба барууны технологийг үндэсний инженерүүдэд ил болгосон бүтээл болсон байна.

ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТУЛГА





# МОНГОЛ УЛС ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 2011/102

*Бүтээлийн нэр*

“Цахилгаан генераторын өдөөлтийн системийн автомат цахим төхөөрөмж”

*Түүрвэсийн сөжөө*

2011 оны 03 сарын 13

*Бүтээлийн төрөл*

Бичмэл бүтээл

*Бүтээл олгогч, түүрвэг*

Намхайн НАЦАГНЯМ

2011 оны 04 сарын 05 өдрийн 26 тоот тушаалаар  
улсын бүртгэлийн 4165 дугаарт авав.



Н.АЛТАНХУЯГ

Улаанбаатар хот

Эрчим хүчний салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлын 2013 оны оны 11 дүгээр сар 8 -ний өдрийн 05 дугаар хэлэлцүүлэгт:

"Хэлэлцсэн нь:

Монголын ЭХСистем бие дааж реактив чадлын эрэлт нийлүүлэлтийн асуудлыг шийдэх чадамжтай болох цогц асуудлуудыг Намхайннацаг ням ХХК – ны дэвшүүлэв. Үүнд:

- NaNyam-AX12 – ыг ДЦС-2 ТӨХК-н Турбин генератор №1 дээр туршсан туршилтын үр дүн
- Шинээр суурилагдах генераторуудын реактансыг зөв сонгох зөвлөмж
- Шинээр суурилагдах генераторуудад ил туйлтай генератор сонгох зөвлөмж
- Сойзгүй өдөөлтийн машины давуу тал
- PSS, Систем Тогворжуулагч Автомат
- NaNyam-AX12 – ийн виртауль лабораторыг ашиглах
- Реле хамгаалалтын координаци хийх

➤ NaNyam-AX12

NaNyam-AX12 типийн өдөөлтийн АРВ системийн давуу тал

Намхайн Нацагнямын зохион бүтээсэн NaNyam-AX12 типийн өдөөлтийн АРВ систем нь хуучин ОХУ – ын АРН – ын гар ажиллагааг автоматжуулсан. Манай станцуудын генераторуудын өдөөлтийн системийн онцлогт тохируулан богино долгионы радио станцын давтамжаас хамгаалах шүүлтүүр хийж, туршилтанд тэнцсэн. мөн реактив чадлын хязгаарлагч бүхий cosφ баригч автоматиктай. Барууны систем дахь cosφ баригч автоматикад реактив чадлын хязгаарлагч байдаггүй. Учир нь Барууных бүх сойзтой өдөөлтийн машинаа сойзгүй өдөөлтийн машинаар сольсон. Манайх сойзтой өдөөлтийн машинтай тул сойз халж шатахаас хамгаалж реактив чадлын хязгаарлагчийг NaNyam-AX12 дахь cosφ баригч автомат-д нэмж өгсөн.

➤ Реактанс сонгох

Манай системийн реактив чадлын эрэлт нийлүүлэлтийг шинээр тооцоолон бодож түүнийг хангаж чадах шинэ эрчим хүчний системийг байгуулахын тулд шинээр байгуулах ТЭЦ бүрийн генераторуудын Реактансыг зөв тооцоолж сонгох хэрэгтэй. Эс тэгвээс ТЭЦS ... ТЭЦ10 хүртэл байгуулсан ч системийн реактив чадлын эрэлт нийлүүлэлтийн асуудлаа шийдэж чадахгүй байнга ОХУ – тай холбоотой байх болно. Бид өөрсдөө системийн реактив чадлын эрэлт нийлүүлэлтээ шийдэж чадвал ОХУ – аас салж тогтвортой ажиллах боломжтой болно. Өнөөгийн системийн чадвар муу тул ОХУ – ын тусламжтайгаар системийн реактив чадлын эрэлт нийлүүлэлтийг шийдэж байгаа.

➤ Ил туйлтай генератор сонгох зөвлөмж

Манай генераторууд далд туйлтай. Харин ALSTOM компаны хэрэглэгчдийн захиалгаас үзэхэд сүүлийн үед ил туйлтай генераторууд борлогдох болсон. Учир нь ил туйлтай

машин нь харьцангуй тогтвортой, тайвшируулах ороомогтой, 2 моменттой,  $X_d = 2.1 * X_q$  гэх мэт давуу талуудтай. Мөн богино залгааны үед аваар эсэргүүцэх чадвар сайтай байдаг.

➤ Сойзгүй өдөөлтийн машины давуу тал

Орчин үеийн өдөөлтийн системийн шийдэл нь өдөөлтийн машингүй тристорны удирдлагатай систем биш. Харин сойзгүй өдөөлтийн машинтай тристорны удирдлагатай систем юм. Өдөөлтийн машиныг хугацааны реле мэтээр буруу ташаа ойлгож түүнийг халж тристор шууд роторын 2000А - ийг удирдах нь хамгийн аюултай шийдэл. Ердийн схемд роторыг өдөөлтийн машины ороомог удирддаг тул аюулгүй. Мөн тристор нь өдөөлтийн машины 100Вт бүхий өдөөлтийн ороомогийг удирддаг тул шатах халах аюулгүй. Өдөөлтийн машиныг хугацааны реле мэтээр буруу ташаа ойлгох явдал байна. Энэ нь нам давтамжийн филтерийн үүрэг гүйцэтгэж автомат тохируулгын нэг чухал хэсэг болдог. Автомат тохируулгын схем нь өндөр болон нам давтамжийн филтерүүдээс бүрддэг тул өдөөлтийн машин R/L характер нь генераторын аваар эсэргүүцэх автоматад сайнаар нөлөөлдөг.

➤ PSS , Power System Stabiliser.

Энэ нь систем тогворжуулагч автомат ба манай бүх генераторуудад тавьж туршилт тохируулга хийхийн тулд нийт системийн динамик характерын тооцоо хийх шаардлагатай. Энэ тооцооны үр дүнгээр энэхүү автоматын тохиргоог зөв хийх боломжтой. Хэрэв буруу тохиргоо хийвэл эсрэгээрээ системийг байнгын савлалтанд оруулж нооль суулгах аюултай

➤ Реле хамгаалалтын координаци хийх

Энэ тооцоог нийт системийн хувьд хийхгүй бол шинэр тавьж буй реленүүд буруу ашиггүй таслалт хийж байна. Үүнээс зайлсхийхийн тулд дотооддоо цахим электрон реле үйлдвэрлэх, реле-ний тавил сонгох тооцоог нийт системийн координацийн хэмжэнд хийх шаардлагатай.

Дүгнэлт:

Дээрхи асуудлыг цогсоор нь шийдснээр Монголын ЭХСистем бие дааж реактив чадлын эрэлт нийлүүлэлтийн асуудлыг шийдэх чадамжтай болно.

Асуулт1:

( ДҮТ – ийн ерөнхий диспетчер Балжинням )

( ДҮТ , Диспетчерийн Үндэсний Төв)

Таний зохион бүтээсэн NaNyam-AX12 синхрон компенсаторыг өдөөж удирдах боломжтой юу? Манай системд компенсатор нэмж тавьна. Эх үүсвэр дээр реактив чадлын асуудлыг шийдэх хэцүү. Иймд бид дэд станцууд дээр компенсатор суурьлуулах төлөвлөгөөтэй байгаа.

Хариулт1:

( Намхайн Нацагням )

Бүрэн боломжтой. NaNyam-AX12 доторхи түлхүүрүүдийн тусламжтайгаар компенсаторын горимыг сонгох боломжтой. Манай системийн реактив чадлын эрэлт нийлүүлэлтийн асуудлыг дэд станцууд дээр компенсатор суурьлуулах замаар шийдэхээс гадна эх үүсвэр дээр ухаалаг өдөөлтийн систем суурьлуулах замаар шийдэж болно.

Асуулт2:

( ДҮТ – ийн ерөнхий диспетчер Балжинням )

Систем тогтворжуулагч зохион бүтээсэн ашиглахад бэлэн гэж ярьлаа. Үүнийг чинь бү үүсгэгч дээр тавьж болох уу?

Хариулт2:

( Намхайн Нацагням )

Болно. Гэхдээ энэ автоматыг тохиргоог хийхийн тулд манай системийн натурал давтамжийг олох хэрэгтэй. Ийм тооцоог Англид хийж байсан.

Английн систем агуу том ч гэсэн тэнд хэсэгчлэх замаар хийдэг. Системийн хаана үүсэх доржилтыг эсэргүүцэх вэ гэдгээс хамаарч хэсэгчилж үлдсэн системийг орлуулдаг. Ийм тооцоог 3 аргаар хийдэг.

1. Цэвэр програм хангамжийн аргаар гэхдээ гадны симулятор биш өөрөө код бичих замаар VC++ ашиглаж хийнэ
2. Цэвэр аналог хэлхээгээр загварчлах
3. Чухал цэгүүд дээр савлалт бичигч суурьлуулж доржилт үүсгэх

Асуулт3:

(Б.Туяа )

Тэгвэл энэ тооцоог нэн яаралтай хийж энэ автоматыг эх үүсвэрүүд дээр яаралтай ажилд оруулах нь зүйтэй. Гэхдээ энэ систем тогтворжуулагч автоматын чинь тохиргоог буруу хийвэл эсрэгээрээ системийг байнгын савлалтанд оруулж нооль суулгах аюултай гэсэн байна. Тохиргоогоо зөв хийж чадах уу?

Хариулт3:

( Намхайн Нацагням )

Манай системийн динамик савлалтын тооцоо хийж натурал давтамжийг зөв олсон үед л боломжтой. Натурал давтамж гэдэг нь роторын савалт. Энэ савлалтыг мэдэж байж систем тогтворжуулагч автоматын тохиргоог хийдэг. Хэрэв натурал давтамжийг буруу тодорхойлвол систем тогтворжуулагч автоматын тохиргоо буруу хийгдэнэ гэсэн үг.

Асуулт:4

(Стратегийн бодлого, төлөвлөлтийн Газрын дарга П.Товуудорж )

ДЦС-2 турбингенератор №1 дээр суурилуулсан NaNyam-AX12 төхөөрөмж хэр найдвартай ажиллаж байгаа вэ? Мөн ямар үнэ өртгөөр гэрээлж хийсэн бэ?

Хариулт4:

NaNyam-AX12 типийн өдөөлтийн систем нь хагас жил ажиллахдаа аваар эсэргүүцэх чадвараараа бусдаас илүү байлаа. Зургаа дугаар сард ОХУ – аас аваарын таслалаар салхад NaNyam-AX12 – ийн удирдаж байсан турбин генератор маш сайн тогтвортой байсан. Иймд NaNyam-AX12 – ийг цаашид манай системийн үлдсэн бүх генераторуудад бодлогоор тавих хэрэгтэй.

Барууны өдөөлтийн системээс NaNyam-AX12 нь техникийн хувьд хоёр давуу талтай байгаа:

1. Орон нутгийн онцлогтой рацияс хамгаалагдсан
2. Сойз халалтыг хамгаалах нэмэлт схемтэй.

Эдийн засгийн хувьд NaNyam-AX12 чинь 99,9% - ийн оюунлаг өртөгтэй. Материаллаг өртөг бараг нооль. Монголд өндөр цалинтай оюунлаг ажлын байр бий болгосон анхны алхам болсон бүтээл. ДЦС-2 ТӨХК-тай 15 сая төгрөгийн гэрээт ажлыг хийж гүйцэтгэсэн. NaNyam-AX12 – ийг зөвхөн манай салбарт бус бусад бүх инженерийн салбарт хэрэглэх боломжтой.

Санал2:

( ДҮТ – ийн срөнхий диспетчер Балжинням )

Эдгээр 7 асуудлыг цогцоор нь шийдээд манай систем ОХУ – аас салаад бие дааж тогтвортой ажиллана гэдэг үнэхээр том асуудал. Энэ их тулгамдсан асуудал. Энэ асуудлуудыг шийдэх гарцыг дэвшүүлж байгаа нь цаг үеэ олон үнэхээр том ажил. Энэ тал дээр бүх талаар дэмжиж ажиллахад бэлэн байна. Манайд байгаа симуляторуудыг үзэж танилцаад биднээс хэрэгтэй мэдээллээ аваад хамтран ажиллаж болно.

Хурлын төгсгөлд Намхайн Нацагнямын зохион бүтээсэн “NaNyam-AX12” типийн өдөөлтийн цахим автомат системийг дэмжих болон 2013 оны технологийн дэвшлийн шилдэг бүтээлийн шагналд нэр дэвшүүлэх санал хураав.

**Санал хураалтын дүн:**

№	Овог нэр	Эрдэмийн цол Ажлын газар Албан тушаал	Санал хураалтын дүн		
			Дэмжсэн	Дэмжээгүй	Өвчтэй чөлөөтэй
1	<b>Д.Доржпүрэв</b>	Хурлын дарга Эрчим хүчний яамны дэд сайд	√		
2	<b>П.Товуудорж</b>	Хурлын дэд дарга ЭХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	√		
3	Г.Энхтайван	ЭХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Хурлын нарийн бичгийн дарга	√		
		Хурлын гишүүд			
4	Ц.Баярбаатар	ЭХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	√		
5	Б. Туяа	ЭХЯ-ны Хяналт шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газрын даргын ҮГ	√		
6	С.Баярбат	ЭХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга			√
7	Ч.Мангалжалав	ШУТИС:ЭХИС-ийн захирал, шинжлэх ухааны доктор, профессор	√		
8	С.Батмөнх	Монгол улсын Шинжлэх ухааны академийн гишүүн, шинжлэх ухааны доктор, профессор	√		
9	Д. Содномдорж	ЭХИС-ийн ЭХХТ-ийн захирал ,төрийн шагналт, Монгол улсын Шинжлэх ухааны академийн гишүүн, шинжлэх ухааны доктор, профессор			√
10	Н.Мягмарсүрэн	Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч, зөвлөх инженер	√		
11	Я. Пүрэвжав	Эрчим хүчний хөгжлийн төвийн дарга	√		
12	Ц.Жаргалсайхан	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ компаний ерөнхий инженер	√		


13	Б.Алтангэрэл	“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын дарга,			√
14	Т. Алтангэрэл	Улаанбаатар дулааны сүлжээ компаний дэд захирал,			√
15	Г. Ёндонгомбо	Терра Глобал компаний захирал			
16	Б.Мөнхөө	Зөвлөх инженер	√		
17	Б.Ганбаатар	Ерөнхийлэгчийн дэргэдэх дэд бүтцийн бодлогын зөвлөлийн нарийн бичгийн дарга			√
18	Д.Балжинням	ТЭЦ-3 ТӨХК-ны ерөнхий инженер, Зөвлөх инженер			√
19	Б. Очиржав	Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн дэд захирал	√		
20	Б.Өрнөхбаяр	Техникийн ухааны доктор, Зөвлөх инженер (тэтгэвэрт) Засгийн Газрын Эрчим Хүчний Референт	√		
21	Д.Дамдинжав	Эрчим хүчний инженерүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, зөвлөх инженер	√		
22	П.Миша	Зөвлөх инженер (тэтгэвэрт) Дархан Сэлэнгийн ЦШСГ дарга			√
		Дэд сайд			√
		Түлш Эрчим хүчний яам			

Зөвлөлийн нийт гишүүд 22 хүн  
 Санал хураалтанд оролцсон 14 хүн  
 Өвчтэй/чөлөөтэй нийт 8 хүн  
 Саналыг дэмжсэн 14 хүн  
 Саналыг дэмжээгүй 0 хүн


**Шийдвэрлэсэн нь:**

Дээрхи санал хураалтын дүнг үндэслэн Намхайн Нацагнямын зохион бүтээсэн NaNyam\_AX12 типийн синхрон генераторын өдөөлтийн автомат систем болон түүний виртауль лабораторыг 2013 оны технологийн дэвшлийн шагналд нэр дэвшүүлэв.

Эрчим хүчний дэд сайд  
 ЭХЯамны ШУТ -н зөвлөлийн дарга

  
 Д.Доржпүрэв

Боловсруулсан:  
 СБТГ-н мэргэжилтэн

  
 Ц.Атаржаргал

“НАМХАЙННАЦАГ НЯМ” ХХК – ИЙН ЗОХИОН БҮТЭЭСЭН “NANYAM-AX12”  
МАЯГИЙН ӨДӨӨЛТИЙН СИСТЕМИЙГ ХҮЛЭЭН АВАХ ТУРШИЛТЫН ПРОТОКОЛ

“НАМХАЙННАЦАГ НЯМ” ХХК-аас шинээр зохион бүтээж ДЦС-2ХК-ий ГЕНЕРАТОР  
№1-д угсрагдсан “NANYAM-AX12” маягийн өдөөлтийн системийг 4-р сарын 18-ий өдөр  
ажилд залган 4-р сарын 21-ий өдрийг хүртэл хамтарсан комисс туршилтын ажлыг хийв.

№	ТУРШИЛТ	ҮР ДҮН
1	NaNyam-AX12 – ийг залгах	Залгасаны дараа ямар нэг доргилт үүсээгүй
2	cosφ – гийн горим баригч буюу MW горимыг шалгах	
2.1	1МВт → 6 МВт өсгөх	МВт ихсэхийн хирээр МВАр автоматаар ихсэж хүчдлийн түвшинг хэвийн түвшинд автоматаар тогторжуулсан. 2 МВАр – аас эхлээд МВАр ихсэлт автоматаар зогссон. Энэ нь сойз хэт халахаас хамгаалж буй аргачлал
2.2	6МВт → 2 МВт бууруулах	6МВт → 2 МВт хүртэл буурах явцад МВАр тогтмол байсан боловч 3 МВт – аас эхлээд автоматаар дагаж буурсан
3	APH – ын горим залгах	Статорын хүчдэл тогтвортой хэвийн байв. AUTO гэсэн потенциометрээр МВАР – ийг ихэсгэж багасгах боломжтойг туршив
4	Маниул горим шалгах	Статорын хүчдэл тогтвортой хэвийн байв. Ш.Р гэсэн потенциометрээр МВАР – ийг ихэсгэж багасгах боломжтойг туршив
5	NB, Null Balance метр шалгах	Энэ метрийн тусламжтайгаар гар болон автоматуудын сувагуудын хооронд шилжүүлэг хийх боломжтойг туршив
6	Кл1 – ээр NaNyam-AX12 – ийг салгаж хуучин APH - ийг шалгах	Кл1 – ээр NaNyam-AX12 – ийг салгаж хуучин APH - ийг ашиглах боломжтойг туршив
7	APH, MW, MVAR гэсэн горимуудаас аль нэгийг сонгох	ТГ1-ын нөхцөлд MW – ын горимоор ажиллах нь техник болон эдийн засгийн хувь илүү их ач холбогдолтойг туршиж батлав
8	MW – ын горимоор ТГ1-ыг 72 цаг ажиллуулж турших	2013 оны 4 дүгээр сарын 19,20,21 ны өдрүүдэд залгаатай орхиж хэвийн ажиллахыг туршиж батлав
9	MW – ын горимоор ТГ1-ыг байнга ажиллуулах	2013 оны 4 дүгээр сарын 21-нээс хойш өнөөг хүртэл амжилттай ажиллаж байна

“NANYAM-AX12” маягийн өдөөлтийн систем нь хөтөлбөрийн дагуу амжилттай туршигдаж найдвартай ажиллагаа нь батлагдсан тул ашиглалтанд хүлээн авахаар комисс шийдвэрлэв.

ДЦС-2ХК-ий ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  
ИА-Ы ДАРГА  
ЦДХАЦ-ИЙН ДАРГА  
ЦТЛ-ИЙН ЭРХЛЭГЧ  
АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР



“НАМХАЙННАЦАГ НЯМ” ХХК ЗАХИРАЛ

Н.НАЦАГНЯМ

**"НАМХАЙННАЦАГ НЯМ" ХХК – ИЙН ЗОХИОН БҮТЭЭСЭН "NANYAM-AX12"  
МАЯГИЙН ӨДӨӨЛТИЙН СИСТЕМИЙГ ХҮЛЭЭН АВАХ ТУРШИЛТЫН ПРОТОКОЛ**

"НАМХАЙННАЦАГ НЯМ" ХХК-аас шинээр зохион бүтээж ДЦС-2ХХ-ий ГЕНЕРАТОР  
ТЭГТ-д угсрагдсан "NANYAM-AX12" маягийн өдөөлтийн системийг 4-р сарын 18-ий өдөр  
ажилд залган 4-р сарын 21-ий өдрийг хүртэл хамтарсан комисс туршилтын ажлыг хийв.

№	ТУРШИЛТ	ҮР ДҮН
1	Nanyam-AX12 – ийг залгах	Залгасаны дараа ямар нэг доргилт үүсээгүй
2	cosφ – гийн горим баригч буюу MW горимыг шалгах	
2.1	1МВт → 6 МВт өсгөх	МВт ихсэхийн хирээр МВАр автоматаар ихсэж хүчдлийн түвшинг хэвийн түвшинд автоматаар тогторжуулсан. 2.1 МВАр – аас эхлээд МВАр ихсэлт автоматаар зогссон. Энэ нь сойз хэт халахаас хамгаалж буй аргачлал.
2.2	6МВт → 2 МВт бууруулах	6МВт → 2 МВт хүртэл буурах явцад МВАр тогтмол байсан боловч 3 МВт – аас эхлээд автоматаар дагаж буурсан.
3	АРН – ын горим залгах	Статорын хүчдэл тогтвортой хэвийн байв. AUTO гэсэн потенциометрээр МВАР – ийг ихэсгэж багасгах боломжтойг туршиж
4	Маниул горим шалгах	Статорын хүчдэл тогтвортой хэвийн байв. Ш.Р гэсэн потенциометрээр МВАР – ийг ихэсгэж багасгах боломжтойг туршиж
5	МВ Null Balance метр шалгах	Энэ метрийн тусламжтайгаар гэр болон автомат сувалуудын хооронд шилжүүлэг хийх боломжтойг туршиж
6	Кл1 – зэр Nanyam-AX12 – ийг салгаж хуучин АРН - ийг шалгах	Кл1 – зэр Nanyam-AX12 – ийг салгаж хуучин АРН - ийг ашиглах боломжтойг туршиж
7	АРН, MW, MVAR гэсэн горимуудаас аль нэгийг сонгох	ТГ1-ын нөхцөлд MW – ын горимоор ажиллах нь техник болон эдийн засгийн хувь илүү их ач холбогдолтойг туршиж батлав
8	MW – ын горимоор ТГ1-ыг 72 цаг ажиллуулж турших	2013 оны 4 дүгээр сарын 19,20,21 ны өдрүүдэд залгаатай орхиж хэвийн ажиллахыг туршиж батлав
9	MW – ын горимоор ТГ1-ыг байнга ажиллуулах	2013 оны 4 дүгээр сарын 21-нээс хойш өнөөг хүртэл амжилттай ажиллаж байна

"NANYAM-AX12" маягийн өдөөлтийн систем нь хөтөлбөрийн дагуу амжилттай туршигдаж найдвартай ажиллагаа нь батлагдсан тул ажиллалтанд хүлээн авахаар комисс шийдвэрлэв.

ДЦС-2ХХ-ийн ЕРӨНХӨЙ ИНОКЕНЕР  
НА-Ы ДАРГА  
ЦДХАЦ-ийн ДАРГА  
ЦТЛ-ийн ЗРХЛЭГЧ  
АШИГЛАЛТЫН ИНОКЕНЕР

**ДУГААРЫ  
ХӨРӨНГӨ АР 6 МЯГМАРЖАВ  
ИЗМЕНТАРЦ БАТБААТАР  
С БАТСАЙХАН  
М БАТСАРП  
Г БАТСҮРЭН**

"НАМХАЙННАЦАГ НЯМ" ХХК ЗАХИРАЛ

Н.НАЦАГНЭМ



## ТОДОРХОЙЛОЛТ

“NaNyam\_AX12” Синхрон генераторын  
автомат тохируулгын талаар өгөх тодорхойлолт

2013 оны 11 дүгээр сар 30

ЭХИС-ийг Цахилгаан системийн автоматжуулалтын мэргэжлээр төгссөн инженер Н.Нацагнямын зохион бүтээж ТЭЦ-2 дээр нэвтрүүлсэн синхрон генераторын өдөөлтийн автоматиктай онолын хувьд нь ЭХИС-ийн ЦСА болон Электроникийн системийн профессоруудын багуудын хамтарсан хурал дээр илтгэлийг сонсож нарийн танилцсаны гадна ТЭЦ-2 дээр очиж бодит байдалтай нь нарийвчлан танилцлаа. Эндээс энэхүү бүтээл нь

Өөрийн орны ашиглалтын нөхцөл байдалд тохируулагдсан, манай орны нөхцөл дэхь өндөр давтамжийн шуугианд нарийн тохируулагдсан зэрэг давуу талуудтай болохыг мэдэрлээ. “NaNyam-AX12” цахим автомат өдөөлтийн системд гадны нөлөөллөөс хамгаалдаг өндөр давтамжийн радио долгионы шүүлтүүрүүдийн time constant тохиргоог Монгол орны хувьд, тухайн цахилгаан станц дээр үүсэж байгаа өндөр давтамжийн шуугианд тохируулан хийснээс гадна өөрийн ашиглалтын нөхцөл байдалд тохируулан тохиргоог хялбараар гүйцэтгэх боломжтой болсноороо ашиглахад хялбар, ажиллагаа нь найдвартай болжээ.

Нөгөө талаар энэ бүтээлийн хүрээнд хийгдсэн программ хангамж, симуляцийн бүтээгдүүнийг “виртаул лабортор” байдлаар оюутан магистрант, инженерүүдэд сургалтын зорилгоор ашиглах бүрэн боломжтой бүтээл болжээ. Мөн үүнийг программ дээр суурилан ЭХС-ийн синхронизмын хяналттай автоматдахин залгагчийн /АПВУС/ талаар виртауль симуляторыг зохион бүтээх боломжтой нь сайшаалтай байна.

Тодорхойлолт гаргасан:

ШУТИС, ЭХИС-ийн

Цахилгаан Системийн Автоматжуулалтын

профессорын багийн тэргүүдэд профессор

МУ Зөвлөх инженер



Док. (Ph.D), проф. Ч.Нацагдорж

Имайл: natsag@must.edu.mn

Утас: 99171785, 2828

2013/NOV/2

# ТОДОРХОЙЛОЛТ

ШУА-ийн тэргүүлэгчдийн газрын эрдэм шинжилгээ, мониторингийн хэлтэс

ШБХХ: NaNyam\_AX12

Хэрэглэгч биш үйлдвэрлэгч Улс болох боломжийг нээлээ!

Намхайннацаг ням ХХК - ийн дотооддоо зохион бүтээсэн цахим электрон NaNyam\_AX12 автоматик нь:

Гаднаас импортлоор авдаг PLC зэргийг дотооддоо үйлдвэрлэх боломжийг нэсэнээрээ гадаадынхантай өрсөлдөх боломжийг олгосон бүтээл болжээ. Матлав симулинк ашиглаж хийдэг автомат стабилизаторыг Барууны үйлдвэрүүдийн адилаар асар бага материаллаг зардлаар хийх боломжийг дотооддоо анх удаа нээлээ. Матлав симулинкын C compiler & hardware зэргийг импортлоор аваад дэлхийтэй өрсөлдөх боломжгүй. Учир нь өөрийн өртөг хэт өндөр болно. Харин Намхайннацаг ням ХХК – ийн энэ бүтээл нь Матлав симулинк болон PLC зэргийг ашиглахгүйгээр эдгээрийг өөрсдөө оюунаараа хийх боломжийг баталлаа.

Намхайннацаг ням ХХК нь өөрийн гэсэн RTOS зохион бүтээж түүнийгээ ашигласан тул PLC бидэнд хэрэггүй. Мөн өөрсдийн зохион бүтээсэн PID функцүүдтэй тул Матлав симулинкын C compiler болон түүний жил бүрийн үйлдвэрлэлийн зориулалтын өндөр үнэтэй license худалдан авах шаардлагагүй боллоо.

Гаднаас асар өндөр үнэтэй импортлодог зүйлсийг өөрсдийн оюунаар зохион бүтээж хэрэглэгч биш үйлдвэрлэгч улс болох боломжийг нэсэн сайн бүтээл болжээ.

"NaNyam-AX12" нь зөвхөн цахилгаан станцад бус инженерийн бүх салбарт борлуулах зах зээл бий. Жишээ нь тристорын удирдлага, инвертерийн удирдлагын хэрэгцээ асар их бий.

Мөн автомат стабилизаторыг виртуаль лаборатор дээр симуляци маягаар турших боломжтой үндэсний анхны виртуаль лаборатор зохион бүтээсэн байна. Энэ нь сургалтын болон үйлдвэрлэлийн асар их ач холбогдолтой.



Г.Алтангэрэл  
ШУА-ийн тэргүүлэгчдийн газрын инноваци  
хариуцсан мэрэгжилтэн

МУ – ын шилдэг зохион бүтээгч,

МУ – ын зөвлөх инженер/

Утас: 99171398

Email: g\_altangerel2002@yahoo.com